

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, хяналтыг
хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Орон нутгийн хөгжлийн сангийн
2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

АУДИТЫН КОД: АРА-2024/26-ШТА-ГА
АРА-2024/26-ШТА-ГА
ДОА-2024/26-8-ШТА-ГА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn
Аудитор Г.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн товёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5

БҮЛЭГ 1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөхдөө иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.....6

1.1.3. Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу бүрэн олгоогүй байна.....	6
1.1.4. Аймгийн ОНХС-д ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг дээр Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасан эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.....	6
1.2.1. Сумын ОНХС-г төлөвлөхдөө 10 сум иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.....	7-8
1.2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.....	8
1.2.3. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.....	8

БҮЛЭГ 2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 88.0 хувьтай байна.....9

2.1.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....	9-11
2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй 92.7 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ байна.....	12-13
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 59 төсөл, арга хэмжээ байна.....	13-14
2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн 5,023.6 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгсөн байна.....	14-15
2.3.1. Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа хөрөнгүүд нийт төсөл, арга хэмжээний 3 хувийг эзэлж байна.....	16
2.3.2. Хадгалалт, хамгаалалтгүй байгаа 255.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.....	17

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хэрэгжилтэд тавих ИТХ-ын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.....17

3.1.1. Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.....	18
3.1.2. Хэрлэн суманд захиалагчийн хяналтыг холбогдох хууль журмын дагуу хийгээгүй байна.....	19
3.1.3. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын 7.7 хувийг хэрэгжүүлэн ажилласан байна.....	19-20
3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.....	20
3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан 71.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.....	21
3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 26.2 хувийг удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.....	20
3.2.4. Шилэн дансны тухай хуулийг 14 сумаас 2 сум хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	21

ДҮГНЭЛТ:.....	22
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....	23
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:.....	24
ЗӨВЛӨМЖ:.....	24-25
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	26-27
ХАВСРАЛТ.....	28-29

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АРА	Архангай аймаг
БА	Барилгын ажил
БО	Байгаль орчин
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДОА	Дорнод аймаг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг, дунд, үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТӨХ	Тендерийн өгөгдлийн хүснэгт
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
УМС	Удирдлага, мэдээллийн систем
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Хөдөө, аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШТА	Шууд тайлагналын аудит
ЭМТ	Эрүүл мэндийн төв
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТАХ-ний зорилтод үр дүндээ хүрээгүй шалтгаан	14
Хүснэгт 2	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	19-20
Хүснэгт 3	Удирдлага, мэдээллийн системд мэдээлэл оруулсан байдал	21-22

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ХАА-ны төрөл	9
Дүрслэл 2	Зорилтод түвшиндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний ангилал	15

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулна.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Дорнод аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны Засаг дарга, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Г.Ганбилэг нар төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 21-нийг өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 06 дугаар дугаар сарын 26-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 07 дугаар сарын 01-ний өдөр Архангай аймаг дахь Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ 1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөхдөө иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

1.1. Аймгийн ОНХС-д ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг дээр уул уурхайн хандив, тусламжаас орох эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.

1.1.3. Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу бүрэн олгоогүй байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 сарын 02-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 11,188.9 сая төгрөгөөр баталсан байна. Харин аймгийн Засаг даргын 2023 оны А/412 дугаар захирамжаар аймгийн 2023 оны ОНХС-гийн шилжүүлгийн хуваарийг баталсан байна. Энэ захирамжаар ОНХНС-гаас сумдын ОНХС-д олгох санхүүжилтийг 11,575.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2023 оны ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу нийт 11,575.8 сая төгрөгийг олгохоос 10,977.6 сая төгрөгийг олгож, 598.2 сая төгрөгийг дутуу олгосон байна. Энэ нь ОНХНС-гаас ирэх орлогын шилжүүлэг дутуу ирсэнтэй холбоотой байна.

Иймд ОНХНС-гаас дутуу шилжүүлсэн орлогын шилжүүлгийн талаар холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

1.1.4. Аймгийн ОНХС-д ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг дээр Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасан эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт ОНХС-гийн эх үүсвэрийг ОНХНС-гаас олгох шилжүүлэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, малын тоо толгойн албан татварын орлого зэргээс бүрдэхээр заасан.

Аймгийн Засаг дарга нь ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг 17,943.1 сая төгрөг дээр нэмж Төсвийн тухай хуулийн 60.2.5-д заасны дагуу ОНХС-гийн эх үүсвэрийг судлан 2023 онд уул уурхайн хандив тусламжаас орох орлогыг 4,637.8 сая төгрөгөөр төлөвлөн ИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн 2023 оны ОНХС-гаас хуваарилагдаж ирэх орлогын шилжүүлэг, уул уурхайн хандив, тусламжийн орлого дээр нэмж бүх сум ОНХС-гийн урьд оны үлдэгдэл болон малын тоо толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж батлуулсан бол түүн дээр нэмж Халхгол сум 510.0 сая төгрөгийг, Цагаан-Овоо сум 35.0 сая төгрөгийг тус тус ОНХС-д орохоор төлөвлөж ИТХ-аар батлуулсан байна.

1.2. Сумын ОНХС-гийн төлөвлөлтийг хийхдээ 10 сум иргэдийн саналгүй нийт 1,940.7 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

1.2.1. Сумын ОНХС-г төлөвлөхдөө 10 сум иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Аймгийн хэмжээнд иргэд 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цаасан, цахим болон бүлгийн ярилцлага хэлбэрээр өгсөн байна.

Аудитын явцад сумдын 2023 оны ОНХС-ийн төлөвлөлтийн баримт бичигт тулган баталгаажуулалт хийхэд дараах 10 сум иргэдийн саналыг аваагүй 1,940.7 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

Баянтүмэн сум: 188.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

1. "Сургуулийн халаалтын тогооны засварын шинэчлэлт"
2. "Сургуулийн компьютерын кабинет"
3. "Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор Вэб сайт"
4. "Иргэний бүртгэлийн киоск машин"
5. "ЭМТөвийн халаалтын пар засвар /цэвэршүүлэх төхөөрөмж/"
6. "Сургуулийн тогооны засвар"

Булган сум: 92.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ

1. "Цэцэрлэг халаалтын тогоо шинэчлэх"
2. "Цахилгаан дамжуулах шугам под станц солих"
3. "Сумын төвийн цахилгаан дамжуулах модон тулгуур солих"
4. "Ногооны талбай хашаажуулах"

Цагаан-Овоо сум: 291.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ

1. "ЕБС-ийн барилгын их засвар"
2. "Мянган зоорь төслийн хүрээнд шинэ зоорь барих"

Баян-Уул сум: 335.4 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ

1. "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор халаалтын радиатор, шугам солих, засварлах"
2. "Замын зураг төсөв зохиох"
3. "Цэцэрлэгийн халаалтын радиатор солих"
4. "Хүүхдийн цэцэрлэгт уурын индүү, угаалгын машин худалдан авах"
5. "Сумын Онцгой комисс, Шуурхай штабын тусгаарлах байрны засвар"
6. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-2"
7. "Орон нутаг судлах танхимын тохижилт"
8. "Хүн болох багаасаа хүүхдийн гадаад хэлний сургалтын тоног төхөөрөмж"
9. "Гамшгийн тусгаарлах байрны хоолны газрын урсгал засвар"
10. "Сумын Онцгой комисс, тусгаарлах байрны тохижилт, үйлчилгээ"
11. "Ойн зурвас, арчилгаа цэвэрлэгээний ажил"
12. "Байгаль орчин хог хаягдал"
13. "Нэг өрх - нэг зүү" хэрэгжилт"
14. "Малын ээмэгжүүлэлт"
15. "TNS олон улсын байгууллагын хамтарч төсөл хэрэгжүүлэх"

Баяндун сум: 193.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

1. "Халаалтын тогоо /ЕБС/"
2. "Гадна тохижилт болон засвар /ЕБС/"
3. "Хэт авианы аппарат /ЭМТ/"
4. "Угтамын рашаан сувиллын тохижилт"
5. "Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт арчилгаа"
6. "Үйлдвэрлэлийн бүсэд дэд бүтэц татах"

Дашбалбар сум: 486.9 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ

1. "Хогийн цэгийн манаачийн байр нүүлгэн шилжүүлэх"
2. "Сумын төвийн шороон зам сайжруулах"
3. "Улз голын гүүрний далангийн ажил"
4. "Цэцэрлэгийн барилгын халаалтын тогооны шинэчлэл"

Сэргэлэн сум: 55.3 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ

1. “Цахилгаан дамжуулах агаарын шугам тавих”
 2. “Үзэмчин үүлдрийн хуцны хөшөөний хашаа барих”,
- Чулуунхороот сум: 234.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ
1. “Сургуулийн гадна орчныг камержуулах”
 2. “Соёлын төвийн дотор 00-д дэмжлэг”
 3. “Гадна гэрэлтүүлгийн засвар”
 4. “Алсын дуудлага, гамшиг ослын үед түргэн шуурхай тусламж үзүүлэх авто машин”
 5. “Ахмад настны чөлөөт цагаа өнгөрүүлэх төвийн байр худалдан авах”
 6. “Сургуулийн хүүхдүүдэд сурах орчныг бүрдүүлэхэд Монгол хэлний кабинетийг тохижуулж засварлахад дэмжлэг үзүүлэх”
 7. “Төсөвт байгууллагын сангийн үйлчилгээ”
 8. “Ахмад настнуудад зуны сувилал, уламжлалт эмчилгээнд хамрагдахад байр гэрийн дэмжлэг үзүүлэх”
 9. “Хилийн боомтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж иргэдийг хилээр нэвтрэх үеийн шуурхай байдлыг хангах пункт барих”
 10. “Онцгой байдлын үед ашиглах хадлан, өвс тэжээлийн агуулах барих”
 11. “Гамшгаас хамгаалах авто пургоны тоноглол, бэхэлгээ хийх”,
- Гурванзагал сум: 29.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ
1. “Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж худалдан авах”
 2. “Аюулгүй нөөцөд хивэг, тэжээлийн нөөц бүрдүүлэх”
 3. “Хуц ухны ангилалт хийх”
 4. “Малчдад зориулсан сургалт, зөвлөгөөн”
- Чойбалсан сум: 34.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ
1. “Тэрбум мод хөтөлбөр”
 2. “Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх”
 3. “Гамшгаас хамгаалах тоног төхөөрөмж”

Иймд иргэдээс санал аваагүй төлөвлөж, хэрэгжүүлсэн дээрх 10 суманд иргэдийн санал авсан төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.

Аймгийн 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна. Тухайлбал,

- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

1.2.3. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Аймгийн 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөлд хийгдсэн аудитаар аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд өгсөн саналыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэхэд тус аудитаар 2.1 тэрбум төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, ОНХС-гийн үйл ажиллагааны журамд нийцээгүй гэж хасах санал өгснөөс 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар сургуулийн гадна авто зогсоол” төсөл, арга хэмжээг 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан байна. Энэ төсөл, арга хэмжээний зураг төсөл нь төсөв батлагдахаас өмнө хийгдээгүй боловч дараа оны 01 сард хийгдсэн байна.

1.2.4. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.1.1-4.5.12-т сумын хэрэгжүүлэх чиг үүргийг заасан байна. Сумдын 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй дараах төсөл, арга хэмжээг төлөвлөж ажилласан байна. Үүнд:


1. **Халхгол сум:** “Зөвлөх үйлчилгээ /БО хамгаалах тухай хууль/ төсөвт өртөг 20.0 сая төгрөг,
2. **Матад сум:** “Тарвага нутагшуулах” төсөвт өртөг 18.0 сая төгрөг,
3. **Булган сум:** “Наадмын талбайн урсгал засвар” төсөвт өртөг 5.0 сая төгрөг, “Наадмын асар майхан” төсөвт өртөг 15.0 сая төгрөг,
4. **Баян-Уул сум:** “TNS олон улсын байгууллагын хамтарч төсөл хэрэгжүүлэх” 6.5 сая төгрөг,
5. **Баяндун сум:** “Дэд бүтэц сайжруулах” төсөл, арга хэмжээний хүрээнд иргэнд олгосон газар чөлөөлөлтийн зардал, төсөвт өртөг 20.0 сая төгрөг,
6. **Сэргэлэн сум:** “Үзэмчин үүлдрийн хуцны хөшөөний хашаа барих” төсөвт өртөг 20.0 сая төгрөг,
7. **Чулуунхороот сум:** “Гамшгаас хамгаалах авто пургоны тоноглол бэхэлгээ хийх” төсөвт өртөг 6.5 сая төгрөгийг төлөвлөсөн нь ОНХС-ийн журмын 4.1.1-4.5.12-т заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.

БҮЛЭГ 2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 88.5 хувьтай байна.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний 53 хувьд шууд худалдан авалт хийсэн байна.

2.1.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих нийт 433 төсөл арга хэмжээнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 82, харьцуулалтын аргаар 98, шууд худалдан авалтаар 213, олон нийтийн оролцоотойгоор /зөвлөх үйлчилгээ/ 6 төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна. Үлдсэн 34 төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагаа зарлах шаардлагагүй ажлууд байна.



Эх сурвалж: ОНХС-ийн нэгдсэн судалгаа, ХАА-ны тайлан

Аймгийн ОНХС-ийн 2023 оны төсөл, арга хэмжээний тендерийн сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгж, компаниудаас Сангийн яаманд хандсан нийт 17 гомдол гаргаж, гомдлыг дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

- Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж үзсэн 3,
- Тендерийг дахин үнэлж шийдвэр гаргах 13,
- Тендерийг дахин зарлах 1 шийдвэрийг гаргаж, үүний дагуу Үнэлгээний хороод тендерийг дахин үнэлэх, дахин зарлах ажлыг журмын дагуу зохион байгуулсан байна.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹, 10.5²-д захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг ижил төстэй байдлаар багцлах, батлагдсан төсвийг хуваахгүй байх талаар заасан.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа ижил, төстэй ажлуудыг багцлалгүй, тендер шалгаруулалт зарлахаас зайлсхийсэн байж болох Баянтүмэн, Булган, Гурванзагал, Матад, Халхгол, Чулуунхороот сумын 344.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээ байна.

Баянтүмэн сум:

- Мал угааврын ванн зүүн гол 2-р баг /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Мал угааврын ванн Хадат 3-р баг /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Гүн өрмийн цооног Хадат 3-р баг /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Гүн өрмийн цооног 3-р баг /Гоожуур, төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Гүн өрмийн цооног 2-р баг /Уйлантын салаа, төсөвт өртөг 20.0 сая төгрөг/

Булган сум:

- Воллейболын талбайг засварлах /Төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Сагсны талбайг засварлах /Төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Цэцэрлэгт хүрээлэн гэрэлтгүүлэх /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/

Гурванзагал сум:

- Ундны усны худгийн байр шинээр барих /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Ундны усны худагт цэвэршүүлэх төхөөрөмж, ухаалаг систем тавих /төсөвт өртөг 13.5 сая төгрөг/
- Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрны камержуулалт /төсөвт өртөг 11.7 сая төгрөг/
- Хүүхдийн цэцэрлэгийн камержуулалт /төсөвт 12.1 сая төгрөг/

Матад сум:

- Гудамжны гэрэлтүүлгийн засвар /Нуур хороолол, төсөвт өртөг 19.7 сая төгрөг/
- Гудамжны гэрэлтүүлгийн засвар /Өнөр хороолол, төсөвт өртөг 19.9 сая төгрөг/

Халхгол сум:

- Худаг сэргээн засварлах 2 худаг /Ялалт баг, төсөвт өртөг 14.0 сая төгрөг/
- Худаг сэргээн засварлах 2 /Ташгай баг, төсөвт өртөг 14.0 сая төгрөг/

Чулуунхороот сум:

- Сургуулийн амралт чөлөөт цагаар хүүхдүүдэд зөв хүмүүжил, хичээл практикийг амьдралд ойртуулах зааж сургах хөдөлмөр зусланг байгуулахад дэмжлэг үзүүлэх /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/
- Сургуулийн амралт чөлөөт цагаар хүүхдүүдэд зөв хүмүүжил, хичээл практикийг амьдралд ойртуулах зааж сургах хөдөлмөр зусланг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, материал худалдан авах /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.2-т тендерийг үнэлэх талаар заасныг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааны аргыг буруу хэрэглэсэн

1 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

2 10.5.Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

Баяндун, Баянтүмэн, Чойбалсан сумын 115.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- **Чойбалсан сум:** “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр” /төсөвт өртөг 30.0 сая төгрөг/-ийг шууд гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн.
- **Баяндун сум:** “Соёлын дэд хөтөлбөр” /төсөвт өртөг 45.8 сая төгрөг/-ийг шууд гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн.
- **Баянтүмэн сум:** ИТХ-ын тогтоолоор 40.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлагдсан “Эрүүл мэндийн төвийн халаалтын пар /цэвэршүүлэх төхөөрөмж/” төсөл, арга хэмжээг тендер зарлалгүй 20.0 сая төгрөгөөр 2 хувааж, шууд худалдан авалт хийсэн байна.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1³-д тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулах, 48 дугаар зүйлийн 48.2.5⁴-д үр дүнг цахим системд нийтлэх, 48.4⁵, 48.5⁶-д баримт бичгийн бүрдлийг ханган архивын нэгж үүсгэх талаар заасан байна.

Сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын баримтуудад хурлын тэмдэглэл, лавлагаа, тодорхойлолт, мэдэгдэл дутуу хавсаргаж, тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулаагүй, худалдан авах ажиллагааны үр дүнг цахим системд дэлгэрэнгүй /шалгарсан аж ахуйн нэгжийн гэрээ, акт/ нийтлээгүй нийтлэг зөрчлүүд илэрч байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 27 дугаар зүйлийн дагуу тендерийг заавар, журмын дагуу үнэлэх талаар заасан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийн шаардлага, шалгуурт заасны дагуу үнэлээгүй 630.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Шинэ болон хуучин хогийн цэгийн тэлэлтийг багасгах арга хэмжээнд зарцуулах бараа материал /төсөвт өртөг 90.0 сая төгрөг/” төсөл, арга хэмжээний тендерийг үнэлэхдээ багц 1-ийн ТШЗ-17.6.1-д заасан тусгай зөвшөөрлийг ирүүлээгүй байхад шалгаруулж, www.tender.gov.mn сайтад тендер шалгаруулалтын үр дүнд тендер амжилтгүй болсон гэх төлөвтэй байх боловч гэрээ байгуулагдсан байна.
2. “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар (Цагаан-Овоо сум), төсөвт өртөг 383.6 сая төгрөг”-ын ажлын тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-17.6.2-т заасан хүний нөөцийн мэдээллийг маягт 4-өөр гаргаж ирүүлээгүй байхад шалгаруулсан байна. Энэ нь тухайн албан тушаалд ажилласан туршлага нь баримтаар нотлогдохгүй байна.
3. “Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал” төсөл, арга хэмжээний “Мал эмнэлгийн тусгаарлагдсан хорио цээрийн дэглэм бүхий эрүүл бүс зураг төсөв, төсөвт

³ 11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

⁴ 48.2.5.тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх;

⁵ 48.4.Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

48.4.1.санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр;

48.4.2.нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл;

48.4.3.захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

48.4.4.захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;

48.4.5.оролцогчдын ирүүлсэн тендер;

48.4.6.үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж;

48.4.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;

48.4.8.захиалагчийн шийдвэр;

48.4.9.худалдан авах гэрээ;

48.4.10.энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;

48.4.11.бусад баримт бичиг.

⁶ 48.5.Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална.

өртөг 50.0 сая төгрөг” багцыг тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-16.1-д заасан өр, төлбөргүй байх шаардлагыг хангаагүй буюу 344.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өртэй компанийг шалгаруулсан байна.

4. “Сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэх төсөл, төсөвт өртөг 57.1 сая төгрөг” арга хэмжээний тендерийг үнэлэхдээ ТӨХ-ийн ТШЗ-15.3-т заасан 2022 оны борлуулалтын орлогын хэмжээ төсөвт өртгийн 20 хувьд хүрэхгүй байхад шалгаруулсан байна.
5. “Хөдөлгөөн-эрүүл мэнд, төсөвт өртөг 50.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний нийтийн бүжиг 1, 2 багцын тендерийг шалгаруулахдаа ТӨХ-ийн ТШЗ-17.6.4-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл ирүүлээгүй, шугаман бүжиг 1, 2, 3 багцад ТШЗ 17.3-т заасан борлуулалтын орлогын хэмжээ, ТШЗ-17.6.4-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл ирүүлээгүй, иог багцад ТШЗ-17.6.4-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл ирүүлээгүй байхад тус тус шалгаруулсан байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй 92.7 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийг журамд зааснаас бусад төсөл, арга хэмжээнд буюу зориулалтын дагуу зарцуулаагүй дараах 7.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. “Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг чадавхжуулах” төсөл, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Сар шинийн өнгө-2023” үзэсгэлэн худалдаа арга хэмжээний шагнал урамшуулал, Тв шторк, азтай худалдан авагч шагнал зэрэг нийт 1,850.0 мянган төгрөг,
2. “Дорнодын хүнс үйлдвэрлэгчид-2023” арга хэмжээний хүрээнд хийсэн телевизийн шторк хөтөлөгчийн хөлс 900.0 мянган төгрөгийг зарцуулсан нь ОНХС-ийн журмын 4.7.6⁷, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4⁸ дэх заалттай нийцэхгүй байна.
3. “ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, олон нийтийг чадавхжуулах зардал” төсөл, арга хэмжээнд 4,946.8 мянган төгрөг зарцуулсан нь ОНХС-ийн журмын 4.2-т заасан чиг үүрэгт хамаарахгүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Сумдын ОНХС-гийн хөрөнгийг журамд зааснаар зориулалтын дагуу зарцуулаагүй дараах 85.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. **Халхгол сум:** “Зөвлөх үйлчилгээ /БО хамгаалах тухай хууль, санхүүжсэн дүн 20.0 сая төгрөг/”, “Малчдын зөвлөгөөн /санхүүжсэн дүн 4.0 сая төгрөг/” хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээнүүд нь журамд нийцэхгүй зориулалт бус, дэмжлэг урамшууллын шинж чанартай зардлууд байна.
2. **Матад сум:** “Тарвага нутагшуулах /санхүүжсэн дүн 18.0 сая төгрөг/ төсөл, арга хэмжээ нь журамд нийцээгүй, сумын чиг үүрэгт хамаарахгүй, “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа /санхүүжсэн дүн 0.8 сая төгрөг/” хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээ нь зориулалт бус, дэмжлэг урамшууллын шинж чанартай зардал байна.
3. **Цагаан-Овоо сум:** “Сургалт зөвлөгөөн, хяналт шалгалт /санхүүжсэн дүн 1.3 сая төгрөг/” хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээ нь журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй, зориулалт бус, дэмжлэг урамшууллын шинж чанартай байна.
4. **Баян-Уул сум:** “ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн, сургалт сурталчилгаа /санхүүжсэн дүн 1.5 сая төгрөг/” хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээ нь журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй, зориулалт бус, дэмжлэг урамшууллын шинж чанартай байна. Мөн “TNS олон улсын байгууллагын хамтарч төсөл хэрэгжүүлэх /санхүүжсэн дүн 6.5 сая төгрөг/” төсөл, арга хэмжээнээс тарваганы байршил тогтоох зорилго бүхий дрон худалдаж авсан нь журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй, зориулалт бус шинж чанартай байна.
5. **Баяндун сум:** “Дэд бүтэц сайжруулах /санхүүжсэн дүн 20.0 сая төгрөг/” төсөл, арга хэмжээний хүрээнд иргэний газар чөлөөлөлтөд олгосон санхүүжилт нь журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй, зориулалт бус, “Соёлын дэд хөтөлбөр /санхүүжсэн дүн 3.5 сая төгрөг/” төсөл, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан тэмцээн, уралдаан, баярын үйл ажиллагаанд зориулсан зардал нь журамд нийцээгүй, зориулалт бус зардал байна.

⁷ 4.7.6. Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.

⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;

6. **Дашбалбар сум:** “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа /санхүүжсэн дүн 2.7 сая төгрөг/” хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээний хүрээнд зарцуулсан тэмцээн, уралдааны урамшууллын зардал нь журмын 4.7.6-д заасан зөвшөөрөхгүй зардалд хамаарч байна.
7. **Чулуунхороот сум:** “Гамшгаас хамгаалах авто пургоны тоноглол бэхэлгээ хийх /санхүүжсэн дүн 6.5 сая төгрөг/” төсөл, арга хэмжээ нь журмын 4.4-т заасан сумын чиг үүрэгт хамаарахгүй, тухайн байгууллагын төсвөөс шийдвэрлэх боломжтой, урсгал зардлын шинж чанартай байна.

Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөс “Наадмын талбайн урсгал засвар” төсөл, арга хэмжээнд 5.0 сая төгрөг, “Наадмын асар майхан” төсөл, хэмжээнд 15.0 сая төгрөг тус тус зарцуулсан нь журамд заасан сумын чиг үүрэгт хамаарахгүй, урсгал зардлын шинжтэй, үндэсний их баяр наадмын зардлаас тусад нь нэмж баталж, хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээнээс чанаргүй, дутуу гүйцэтгэсэн 879.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- “Мянган зоорь төслийн хүрээнд зоорийн засвар /Цагаан-Овоо сум, төсөвт өртөг 200.0 сая төгрөг/”-ын ажлын цахилгааны холболтыг хийж гүйцэтгээгүй, үүрэг даалгавраар хүлээж авсан ч одоог хүртэл хэрэгжүүлээгүй байна.
- “Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн барилгын гадна засвар /Хэрлэн сум 7 дугаар баг, төсөвт өртөг 460.4 сая төгрөг/”-ын хүрээнд хийгдсэн гадна чулуун эмульс нь сургуулийн хойд, баруун, урд хэсэгт нуралт үүссэн байна.
- “9 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар /Хэрлэн сум 9 дүгээр баг, төсөвт өртөг 218.8 сая төгрөг/”-ын ажлын зураг, төсөвт тусгагдсан гал тогооны агаар сэлгэлтийн систем нь хэвийн горимд ажиллахгүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээнээс дутуу, чанаргүй гүйцэтгэсэн 1,510.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- **Цагаан-Овоо сум:** “Стандарт эмийн сан, лабораторийн барилга /төсөвт өртөг 299.9 сая төгрөг/”-ын ажлыг гүйцэтгэсэн “Шинэ эрин инженериг” ХХК нь цахилгаан, цэвэр, бохирын шугамыг дутуу гүйцэтгэсэн байна. Үүнээс шалтгаалан өнгөрсөн өвөл цэвэр ус, 00 ажиллагаагүй байна.
- **Булган сум:** Булган сумын ОНХС-ийн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогийн цэг хашаажуулах” төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэж, ашиглалтын шаардлага хангахгүй байна.
- **Хөлөнбуйр сум:** “Хүүхэд залуучуудын талбайн засварын ажил /төсөвт өртөг 35.0 сая төгрөг/”-ыг гүйцэтгэсэн “Санаа мед трейд” ХХК нь зураг, төсөвт зааснаар сагсан бөмбөгийн талбайг резинэн будгаар будах ажлыг дутуу гүйцэтгэсэн байна.
- **Чойбалсан сум:** “Хүүхэд болон ахмадын сувиллын байрны торх /төсөвт өртөг 65.7 сая төгрөг/-ны ажил нь чанаргүй хийгдсэнээс шалтгаалж дээврийн төмөр нь салхинд хууларсан байдалтай байна.
- **Хэрлэн сум:** “Ахлах сургуулийн барилгын их засвар /Шинэ хөгжил цогцолбор сургууль, төсөвт өртөг 980.3 сая төгрөг/”-ын ажлыг “Мишээл кристалл хаус” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Ашиглалтад хүлээлгэж өгснөөс хойш гадна тамбурын хаалга, ангиудын хаалганы цоож, шалны хүрээ зэрэгт эвдрэл гэмтэл үүсэж, ханын эмульс халтартах, ариун цэврийн ерөөний ханын плита ховхрох, шалны хулдаас салах зэрэг доголдлууд гарсан нь чанаргүй гүйцэтгэлтэй холбоотой байна. Үүний дагуу 2023 оны 11 дүгээр сараас эхлэн тус компани 2023 оны 03 дугаар сард биеийн тамирын залны таазыг будаг, гэрэлтүүлэг, гадна тамбурын хаалганы ажлыг дахин гүйцэтгэсэн байна. Цаашид гарч буй доголдлыг арилгах шаардлага үүссэн байна.
- “Эгнээ гудамжнууд дундуур явган хүн зорчих хэсгийн замыг сайжруулах хатуу хучилттай болгох / 4 дүгээр баг/ төсөвт өртөг 110.0 сая төгрөг/ ажлыг “Дорнод авто зам” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Ашиглалтын явцад эвдрэл гэмтэл ихээхэн гарч байгаа нь чанаргүй гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

2.2. Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа хөрөнгүүд нийт хөрөнгө оруулалтын ажлын 13 хувийг эзэлж байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 59 төсөл, арга хэмжээ байна.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 7,307.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 1. "ТАХ-ний зорилтод түвшиндээ хүрээгүй шалтгаан"

№	Эх үүсвэр	Зорилтод түвшиндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний тоо				Төсөвт өртөг /сая.төг/
		ИТХ-ын тогтоолоор хасагдсан ТАХ-ны тоо	Хэрэгжилт дутуу ТАХ-ны тоо	Хэрэгжээгүй, он дамжих ТАХ-ны тоо	Огт хэрэгжээгүй ТАХ-ны тоо	
1	2	3	4	5	6	7
1	Аймгийн ОНХС	2	5	6	-	5,223.3
2	Сумдын ОНХС	1	8	2	35	2,084.3
	НИЙТ	3	13	8	35	7,307.6

Эх үүсвэр: ОНХС-ийн нэгдсэн судалгаа

Дүрслэл 2. "Зорилтот түвшинд хүрээгүй төсөл арга хэмжээний ангилал"



Эх сурвалж: "ОНХС-ийн нэгдсэн судалгаа"

Зорилтот түвшиндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд 5 хувь нь ИТХ-ын тогтоолоор хасагдаж, 14 хувь нь он дамжин хэрэгжих ТАХ, 22 хувь нь хэрэгжилт дутуу тайлант онд хэрэгжиж дуусаагүй ТАХ, 59 хувь нь огт хэрэгжээгүй ТАХ эзэлж байна. /Дэлгэрэнгүй судалгаа тайлангийн хавсралт №1/

Огт хэрэгжээгүй 1,022.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 35 төсөл, арга хэмжээ байна. Хэрэгжээгүй шалтгаан нөхцөл нь сумдад малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүй, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээ байгуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Он дамжин хэрэгжих 1,501.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна. Гүйцэтгэл гараагүй шалтгаан нь 2023 онд гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс гүйцэтгэл гараагүй, гэрээг он дамжуулан байгуулсантай холбоотой байна.

Хэрэгжилт дутуу 2,545.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ байгаагаас тухайн ажлуудын гүйцэтгэл 30-90 хувьтай байна. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд нь захиалагчтай байгуулсан гэрээг тайлант оны сүүлд байгуулж, ажлаа оройтож эхэлсэнтэй холбоотойгоор гэрээний хугацааг сунгасан байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн 5,023.6 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгсөн байна.

Аймгийн ОНХС-ийн 1,741.3 сая төгрөгөөр хийгдсэн дараах 3 төсөл, арга хэмжээнүүд орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажлууд болсон байна.

Үүнд:

- Илч хорооллын хайрган хучилттай авто замын хатуу хучилттай автозам болгон барих ажил нь 819.9 сая төгрөгөөр хийгдэж, иргэд чанартай автозамаар зорчиж, хөрөнгө оруулалтын ажлын үр шимийг хүртэж эхэлсэн байна.
- Усан хангамжийн эх үүсвэрийн Хэрлэн гол доогуурх дюкерийн байгууламж, ф400мм-ийн голчтой 180м шугам сүлжээний хаалт шинэчлэх ажил нь 505.5 сая төгрөгөөр хийгдэж, Чойбалсан хотын иргэдийн эрүүл, аюулгүй усаар хангагдах нөхцөл бүрдсэн байна.
- Усан хангамжийн магистрал шугамыг шинэчлэх /Хэрлэн сумын 3-р баг/ ажил нь 415.9 сая төгрөгөөр хийгдэж, зэвэнд идэгдсэн хуучин шугамыг сольсноор иргэд чанартай усыг хэрэглэх нөхцөл бүрдсэн байна.

Сумдын ОНХС-ийн 3,282.3 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн дараах 18 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхөөр үр нөлөөтэй ажлууд болсон байна. Үүнд:

Хэрлэн сум:

- Явган зам шинээр байгуулах /2, 3, 7-р баг/ ажлыг 110.0 сая төгрөгөөр, Эгнээ гудамжууд дундуур явган хүн зорчих хэсгийн замыг сайжруулах хатуу хучилттай болгох /4 дүгээр баг/ ажлыг нийтдээ 248.3 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэж, иргэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн байна.
- Төв зам дагуух гэрэлтүүлэг /1 дүгээр баг/-ийн ажлыг 30.0 сая төгрөгөөр, Төв зам дагуух гэрэлтүүлэг /3 дугаар баг/-ийн ажлыг 90.1 сая төгрөгөөр, Гэр хорооллын эгнээнд гудамжны гэрэлтүүлэг /4 дүгээр баг/-ийн ажлыг 89.5 сая төгрөгөөр, Гэр хорооллын эгнээнд гудамжны гэрэлтүүлэг /11 дүгээр баг/-ийн ажлыг 99.8 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн байна.
- Орон сууны 22, 23 дугаар байрны гадна талбайн тохижилтыг 224.0 сая төгрөгөөр, Орон сууны байруудын гадна тохижилт /9-р баг/-ийн ажлыг 124.6 сая төгрөгөөр гүйцэтгэж, хүүхэд, хөгшид, залуучуудын эрүүл мэнд, бие бялдрыг дэмжсэн, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд таатай орчныг бүрдүүлсэн байна.

Баянтүмэн сум:

- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах тусгай чиг үүргийн албан хэрэгцээнд ариутгалын машиныг 48.5 сая төгрөгөөр худалдан авч, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гал түймэр унтраах, мод үржүүлэг зэрэг ажилд давхар ашиглаж байгаа нь үр дүнтэй ажил болсон байна.

Булган сум:

- Хүүхэд залуучуудын талбайг тохижуулах ажлыг 53.1 сая төгрөгөөр гүйцэтгэж, иргэдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмжсэн ажил болсон байна.

Гурванзагал:

- Ерөнхий боловсролын сургуулийн гадна сагсны талбай байгуулах ажлыг 150.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмжсэн ажил болсон байна.

Дашбалбар сум:

- Сумын ОНХС-ийн 921.7 сая төгрөгөөр төрийн албан хаагчдын орон сууц барьсан нь Монгол Улсын Засгийн газар, орон нутаг бүс нутгийн хэмжээний бодлогын баримт бичигт

нийцсэн, ажлын байрыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ажил болсон байна.

Матад сум:

- Гудамжны гэрэлтүүлэг /Нуур, Өнөр хороолол/-ийн ажлыг 39.6 сая төгрөгөөр гүйцэтгэж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Сэргэлэн сум:

- Цэвэршүүлэх төхөөрөмж бүхий гүн өрмийн худгийн ажлыг 39.9 сая төгрөгөөр гүйцэтгэж, иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангагдах нөхцөл бүрдсэн байна.

Халхгол сум:

- Зэвсэгт хүчний 329-р ангиас сумын төв хүртэлх зам засварын ажлыг 600.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, иргэд чанартай автозамаар зорчиж, хөрөнгө оруулалтын ажлын үр шимийг хүртэж эхэлсэн байна.

Цагаан-Овоо сум:

- Төвлөрсөн хогийн цэгийг ландфилийн аргаар булшилж тохижуулах ажлыг 175.5 сая төгрөгөөр иж бүрнээр нь гүйцэтгэж, байгаль орчин болон иргэдийн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлсэн ажил болсон байна.

Чойбалсан сум:

- Гудамж тохижилт, Цайдам гудамж төслийг 217.2 сая төгрөгөөр гүйцэтгэж, сум, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн ажил болсон байна.

Чулуунхороот сум:

- Хүн болох багаасаа хөтөлбөрийн хүрээнд жишиг анги-2 төслийг 20.0 сая төгрөгөөр хэрэгжүүлж, хүүхдийн хөгжил болон багш ажилчдын ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгө оруулалтын ажлуудад ашиглалт, хадгалалт, хамгаалалтгүй байгаа хөрөнгүүд бий болсон байна.

2.3.1. Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа хөрөнгүүд нийт төсөл, арга хэмжээний 3 хувийг эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зориулалтын дагуу бүрэн ашиглагдахгүй байгаа нийт 2,750.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн дараах 1,484.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ нь хэрэгжсэн боловч бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна. Үүнд:

- Орон нутаг судлах танхимын өргөтгөл /Сэргэлэн сумын соёлын төв/, төсөвт өртөг 65.0 сая төгрөг (2 эх үүсвэртэй). Аймгийн ОНХС, сумын ОНХС-гийн 2 эх үүсвэртэй баригдсан орон нутаг судлах танхим нь ашиглалтгүй байна.
- Чойбалсан хотын төв хогийн цэгийн цахилгаан дамжуулах шугам, дэд станц, гүний худаг 220.0 сая төгрөг. Шинээр хогийн цэг байгуулсантай холбоотой хийгдсэн худаг, дэд станц, ЦДАШ нь одоогоор ашиглалтгүй байна.
- Бохир татан зайлуулах шугам хоолой /Хэрлэн сум, 1 дүгээр баг/, төсөвт өртөг 100.0 сая төгрөг. Хэрлэн сумын 1 дүгээр баг, Зэвсэгт хүчний 327-р ангиас урагш чиглэлд хийгдсэн бохирын шугам нь ашиглалтгүй байна.
- Зангиат хороолол болон хүүхдийн цэцэрлэгийн дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан, холбооны шугам /Хэрлэн сум, 4 дүгээр баг/, төсөвт 862.4 сая төгрөг. Хэрлэн сумын 4 дүгээр багт байрлах шинэ цэцэрлэгийн гадна талд баригдсан дэд станц, бохирын шугам, урагш чиглэлд хийгдсэн бохирын шугам, холбооны шугам нь одоогийн байдлаар ашиглалтгүй байна.
- Цахилгаан дамжуулах агаарын шугам /Булган сум/, төсөвт өртөг 94.0 сая төгрөг. Иргэд, ААН-ийн ногооны талбай руу татсан агаарын шугам нь бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.
- Мянган зоорь төслийн хүрээнд зоорийн засвар /Баяндун сум/ төсөвт өртөг 143.0 сая төгрөг. Баяндун суманд хийгдсэн зоорийн байгууламж нь 2023 онд ашиглалтад орсон боловч ашиглаж эхлээгүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн дараах 1,165.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ нь хэрэгжсэн боловч ашиглалтгүй байна. Үүнд:

- **Булган сум:** “Хогийн цэгийн хашаажуулалт /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/” нь ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл үүсэж, ашиглалтын шаардлага хангахгүй байна.
- **Сэргэлэн сум:** 1. “ЦДАШ тавих /төсөвт өртөг 35.3 сая төгрөг/”, “Орон нутаг судлах танхим /төсөвт өртөг 65.0 сая төгрөг/”, “Сумаас орж гарах хаягийн тэмдэг /төсөвт өртөг 1.8 сая төгрөг/ зэрэг төсөл арга хэмжээ нь ашиглалтгүй байна.
- **Халхгол сум:** “Универсал трактор /төсөвт өртөг 125.0 сая төгрөг/” нь ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл гарсан байна.
- **Цагаан-Овоо сум:** “Стандарт эмийн сан, лабораторийн барилга /төсөвт өртөг 299.9 сая төгрөг/”-ын ажилд цахилгаан, цэвэр, бохир усны шугамын ажил дутуу хийгдсэнээс шалтгаалж, бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байна. Мөн “Цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станц /төсөвт өртөг 506.2 сая төгрөг/”, “Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /төсөвт өртөг 112.6 сая төгрөг/”-ийн ажлууд нь хийгдсэн боловч иргэд ашиглаж эхлээгүй байна.

2.3.2. Хадгалалт, хамгаалалтгүй байгаа 255.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁹, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.12¹⁰-т ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоо гаргаж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцахаар журамд заасан.

Хэрлэн сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 255.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд хадгалалт, хамгаалалт байхгүйгээс эвдрэл, гэмтэл үүсэж байна.

- Хэрлэн сумын “Тоглоомын талбай байгуулах, орчны тохижилт / 2 дугаар баг, төсөвт өртөг 155.4 сая төгрөг/ төсөл, арга хэмжээ 2022 оноос эхэлж хийгдэж, гүйцэтгэл 90 хувьтай байгаа ч бүртгэлд тусгаагүй, хариуцах эзэн байхгүйгээс эвдрэл, гэмтэл үүссэн байна. Мөн “Орон сууцны байруудын гадна тохижилт /8 дугаар баг, төсөвт өртөг 100.0 сая төгрөг/ төсөл, арга хэмжээний хадгалалт, хамгаалалт муу байгаагаас хийгдсэн ажлууд ашиглалтын шаардлага хангахгүй байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хэрэгжилтэд тавих ИТХ-ын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.1 Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4¹¹-д

⁹ 29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

¹⁰ 9.12. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

¹¹ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо хяналт тавьж ажиллахаар заасан.

Аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх бодлогын хороод, ажлын хэсгийн баримт материалтай тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлэхэд хяналтын хороод 2023 онд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.

Цаашид төсөл арга хэмжээний чанар, үр дүнг хэлэлцэж, илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж, дүгнэлт гаргаж, нотлох баримтаар дэмжигдэхүйц хяналтын тайланг гаргаж байх шаардлагатай байна.

3.1.2. Хэрлэн суманд захиалагчийн хяналтыг холбогдох хууль журмын дагуу хийгээгүй байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4¹², Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д барилга, байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх талаар заасан.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ хуульд заасан эрх, үүргийн хүрээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг Дорнод аймгийн ГХБХБГ-тай байгуулж, тус гэрээний дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулснаар санхүүжилтийг олгосон байна.

Хэрлэн сумын ЗДТГ нь 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Хэрлэн сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн зөрүүтэй ойлголтоос шалтгаалсан байна.

3.1.3. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын 7.7 хувийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас ОНХС-ийн 2022 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар 6 албан шаардлага, 7 зөвлөмж өгснийг 7.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Удирдлага мэдээллийн системд төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг журамд заасны дагуу мэдээлж ажиллах гэсэн зөвлөмжийг аймаг болон 11 сумын Засаг дарга нар хэрэгжүүлж ажиллаагүй байна.

байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

¹² 37.1.4. Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах

Шилэн дансны цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх гэсэн зөвлөмжийг Матад сумын Засаг дарга хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 2. “Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт”

Д/Д	Зөрчлийн төрөл	Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь
1	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	1	0		
2	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	3	0		
3	Ашиглалтгүй байгаа төсөл арга хэмжээ	2	0		
4	ИТХ хяналтыг хэрэгжүүлж ажиллах			1	0
5	Орлогын эх үүсвэрийг судалж, ИТХ-аар батлуулах.			1	100
6	Зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бий болгох			1	0
7	Ашиглалттай холбоотой асуудлыг тооцож төлөвлөж байх.			1	0
8	Техникийн тодорхойлолтыг бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулан баталж байх.			1	0
9	Удирдлага мэдээллийн системд төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг журамд заасны дагуу мэдээлж ажиллах.			1	0
10	Шилэн дансны цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.			1	0

Эх сурвалж: Дорнод аймаг дахь ТАБ-ын 2023 оны жилийн эцсийн статистик мэдээ

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2023 оны ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна. Аудитаар хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой алдаа, зөрчлийг илрүүлж холбогдох байгууллага албан тушаалтанд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Цаашид төсөв захирагч нар хөндлөнгийн болон дотоод аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг журмын Сангийн яаманд дагуу хүргүүлсэн ч, зарим төсөл, арга хэмжээг үртгэл тайланд тусгаагүй байна.

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2¹³, 9.9¹⁴-д заасны дагуу холбогдох байгууллагуудад, заасан хугацаанд тайлан, мэдээг хүргүүлэхээр заасан.

¹³ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

¹⁴ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

Аудитаар сумдын ЗДТГ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажилласан байна. Аймгийн ЗДТГ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын дагуу ОНХС-гийн 2023 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдөр сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан 71.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2¹⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2¹⁶-д төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгахаар заасны дагуу ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 21,645.8 сая төгрөгийн 281 хөрөнгө оруулалт, ТАХ-ээс 21,644.6 сая төгрөгийн 276 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, эзэмшигч байгууллагын даргын тушаал зэргийг үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгажээ.

Харин ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 71.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Тухайлбал:

- Дашбалбар сумын 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын халаалтын тогооны шинэчлэл”
- Баяндун сумын 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Угтамын рашаан сувиллын тохижилт”
- Хөлөнбуйр сумын 8.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хог шатаах зуух зураг төсөв”
- Матад сумын 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гар худаг шинээр засварлах төхөөрөмж”
- Баянтүмэн сумын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор веб сайт”

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Хөрөнгийг бүртгэл, тайлант тусгаагүй байгаа нь хөрөнгийн ашиглан үүсэх, хөрөнгө дутагдах, хууль зөрчигдөх, албан тушаалтан хариуцлага хүлээх эрсдэлтэй.

3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 26.2 хувийг удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг заасан хугацаанд удирдлагын мэдээллийн системд оруулахаар заасан ч мэдээллээ бүрэн байршуулаагүй байна.

Аудитаар удирдлага мэдээллийн системд оруулсан мэдээллийг анхан шатны баримт, материалтай тулган шалгахад аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 26.2 хувийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

Хүснэгт 3. “Удирдлага, мэдээллийн системд мэдээлэл оруулсан байдал”

¹⁵ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

¹⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

№	Аймаг, сум	Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо	УМС-д бүртгэсэн төсөл, арга хэмжээний тоо	УМС-д дутуу мэдээлсэн төсөл, арга хэмжээний тоо
1	Аймгийн ОНХС	74	66	8
2	Хэрлэн сум	25	25	0
3	Чулуунхороот сум	33	0	33
4	Чойбалсан сум	16	8	8
5	Сэргэлэн сум	30	26	4
6	Гурванзагал сум	16	5	11
7	Дашбалбар сум	26	26	0
8	Баян-Уул сум	37	37	0
9	Булган сум	35	25	10
10	Баяндун сум	29	26	3
11	Хөлөнбуйр сум	19	14	5
12	Баянтүмэн сум	30	9	21
13	Халхгол сум	23	21	2
14	Матад сум	35	27	8
15	Цагаан-Овоо сум	22	17	5
	НИЙТ	450	332	118

Эх сурвалж: ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем

3.2.4. Шилэн дансны тухай хуулийг 14 сумаас 2 сум хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.1¹⁷, 6.3.9¹⁸ дэх заалтуудаар шилэн дансны www.shilendans.gov.mn цахим сайтад байршуулахаар тусгайлан зааж өгсөн байна. Шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулж ажилласан эсэхийг тулган үзэхэд:

- Матад сум шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн 7 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй, 34 арга хэмжээний хэрэгжилтийг оруулаагүй байна.
- Булган сум иргэд, олон нийтэд санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Сумын ЗДТГ нь шилэн дансны мэдээллийн самбаргүй байна.

¹⁷ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

¹⁸ орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу бүрэн олгоогүй байгаа нь ОНХС-гаас орлого дутуу ирсэнтэй холбоотой байна. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасан уул уурхайгаас орж ирэх орлогыг нэмж төлөвлөсөн байна.
2. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна. Харин 10 сум иргэдийн саналгүй нийт 1,940.7 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан нь хууль журмын дагуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна. Мөн төсвийн тухай 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй 1 төсөл, арга хэмжээ, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.
3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй нь аймгийн үнэлгээний хороод ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй 112.5 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ байгаа нь хууль, журмыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 59 төсөл, арга хэмжээ байгаа нь аймгийн ИТХ-ын тогтоолоор хасагдсан, хэрэгжилт дутуу, он дамжуулан хэрэгжүүлж байгаатай холбоотой байна. ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн 5,023.6 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээнүүд нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, орчны тохижилтыг сайжруулах, ажлыг байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн хөгжил дэвшилд хувьд нэмрээ оруулсан хөрөнгө оруулалтууд бий болжээ.
5. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа хөрөнгүүд байгаа нь нийт төсөл, арга хэмжээний 3 хувийг эзэлж байна. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ байна.
6. Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Сумд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, алан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Мөн Хэрлэн суманд захиалагчийн хяналтыг гэрээ байгуулаагүй хэрэгжүүлж, хяналтын зардлыг зарцуулсан байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан боловч 71.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Аймаг, суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 26.2 хувийг удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй, Шилэн дансны тухай хуулийг 2 сум хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд илэрлээ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүвшингийн гудамж, 9 дүгээр баг
Хархир сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4252, факс: 7058-4364
Цахим хуудас: zsdg@domod.gov.mn
Цахим хуудас: domod.gov.mn

2024.07.02 № 1/1463

талай _____ ны № _____ -т

Тайлангийн хариу хүргүүлэх тухай

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Үүнд:

1. "Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг чадавхжуулах" төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхдээ Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа ажлын байрыг дэмжих, борлуулалтыг нь нэмэгдүүлэх, шинэ санаа, шинэ бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор тухайн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

Телевизийн шторк нь зохион байгуулж буй үзэсгэлэн худалдааг олон нийтэд таниулан сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд шагналыг тухайн үзэсгэлэн худалдаанд оролцсон Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнээс худалдан авч борлуулалтыг дэмжсэн үйл ажиллагаанд зарцуулсан.

2. Удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд олон нийтийг чадавхжуулах зорилгоор сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгийн гишүүд, багийн Засаг дарга нараар дамжуулан хурлын төлөөлөгч, иргэд, малчид Орон нутгийн хөгжлийн сангийн бусад оролцогчдыг чадавхжуулах нь зохистой гэж үзэж уг сурталтыг зохион байгуулсан.

Сургалтаар олж авсан мэдлэг мэдээллийг оролцогчид түгээн дэлгэрүүлж 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний саналыг Удирдлагын мэдээллийн систем болон гар утасны аппликейшн ашиглан нийт 29,253 иргэн санал өгөөд байна.

Иргэдийн идэвх, санаачилга, оролцоо, хяналтыг нэмэгдүүлэхэд сумын төрийн албан хаагчдаар дамжуулан иргэдэд мэдээлэл түгээх нь онцгой бөгөөд сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, иргэдийн төлөөлөгчдийн хурлын хяналтын хорооны гишүүд, иргэдийн төлөөлөлд Орон нутгийн хөгжлийн сангийн цахим хуудаснаас өөрийн болон бусад сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээлэл хэрхэн авахыг таниулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2124061090

2

Иймд дээрх 2 арга хэмжээтэй холбоотой төлбөрийн актыг албан шаардлага болгуулах саналтай байна.

3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийн шаардлага, цалгуурт заасны дагуу үнэлсэгүй 3,291.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээтэй холбоотой тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.

Хавсралт: 33 хуудастай



ОРЛОГЧ Ш.ЕЛ

Аудитын тайлангийн 2.1.1-ийн 4 дэх хэсэг, 2.1.2 дахь хэсэгт заасан зориулалт бус зарцуулалт, худалдан авах ажиллагааны үнэлгээтэй холбоотой асуудалд холбогдох байгууллагаас ирүүлсэн тайлбарыг үнэлж, дараах өөрчлөлтийг тусгав. Үүнд:

1. Аудитаар аймгийн Засаг даргад тогтоосон төлбөрийн актад өгсөн тайлбарт бодитой байх шаардлагыг хангахгүй байх тул 2.7 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг хэвээр үлдээв.

2. Худалдан авах ажиллагааны 3,291.4 сая төгрөгийн 18 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд өгсөн тайлбарын дагуу 2, 3, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 14, 15, 18 дахь асуудлыг зөрчлийн дүнгээс хасаж, бусад хэсэгт өгсөн тайлбар нь баримтаар нотлогдохгүй, бодитой, үндэслэлтэй байх шаардлагыг хангахгүй байх тул тайланд хэвээр үлдээхээр шийдвэрлэв. Тухайлбал:

- Тусгай зөвшөөрөл шаардсан тендерт шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулж, www.tender.gov.mn сайтад амжилгүй болсон төлөвт байгаа тохиолдолд тендерийг дахин зарлаж, үнэлэх шаардлагатай байсан.

- Цаг хугацаа, онцлог ажлын хувьд ажил гүйцэтгэхэд шууд нөлөөлөх үр нөлөөг үнэлсэн нь батлагдсан тендерийн баримт бичгийг мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотой бөгөөд энэ нь тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна. Үүнд: ТШЗ дэх хүний нөөцийн батлагдсан маягт, борлуулалтын орлого, ижил төстэй гэрээний мэдээлэл зэрэг хамаарна.

ХХОАТ-ийн өр төлбөргүй байх нь ТӨХ-ТШЗ-ны салшгүй хэсэг байх бөгөөд шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл болж байна.

САНАЛ:

Хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх дараах 2 асуудлыг Үндэсний аудитын газарт уламжилж байна.

1. Аудитаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийн шаардлага, шалгуурт заасны дагуу үнэлээгүй 630.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна.

2. Төсвийн хөрөнгөөр суманд бий болсон хөрөнгийг /Дашбалбар сумын төрийн албан хаагчийн орон сууц/ төрийн албан хаагч хувьдаа ашиглаж байж болзошгүй байна.

Иймд эдгээр асуудал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн байж болох тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр болон сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөж байна. Үүнд:

1. ОНХС-ийн төсөл, арга хэмжээ бүрийн чанар, үр дүнгийн талаар хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох нотлох баримтаар дэмжигдсэн зөвлөмж, дүгнэлт бүхий тайлан бэлтгэж, үр дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулах.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд зөвлөж байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, үнэлэхийг Худалдан авах ажиллагааны газар, сумдын үнэлгээний хороодод үүрэг болгох.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс зорилтот үр дүндээ хүрээгүй ажлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах. /Тайлангийн хавсралт №1/
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,484.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний ашиглалтыг сайжруулахад анхаарч ажиллах.

Сумдын Засаг дарга нарт /Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Матад, Сэргэлэн, Халхгол, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот/:

1. ОНХС-ийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын баримтын иж бүрдлийг хангаж, тендерийг хууль, журмын дагуу үнэлэх, цахим системд шалгарсан аж ахуйн нэгжийн гэрээ, актыг дэлгэрэнгүй оруулж, үр дүнг иргэд, олон нийтэд нээлттэй байдлаар мэдээлж ажиллах.
2. Худалдан авах ажиллагааг зарлахдаа Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баримтлах, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.2, 10.3-т заасныг үндэслэн батлагдсан төсөвт өртгийг хувааж тендер зарлахгүй байх, зориулалт, нэр төрөл, газар зүйн байршлыг харгалзан ижил төстэй ажлуудыг багцалж тендер зарлах. /Тайлангийн 2.1.1-ийн 1, 2 дахь хэсэг, нийт 420.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ/
3. Сумын ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахгүй байх.

4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, томоохон төсөвт өртөгтэй барилга байгууламж, их засварын ажилд тавих захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд анхаарч, зорилтот үр дүндээ хүрээгүй ажлуудын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах. /Тайлангийн хавсралт №1-ээс үзэх/
6. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах. /Тайлангийн 2.3.1, 2.3.2 дахь хэсэг, нийт 1,165.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ/

Хэрлэн сумын Засаг даргад:

1. Худалдан авах ажиллагаанд шалгарсан аж ахуйн нэгжийн гэрээ, актыг цахим системд дэлгэрэнгүй оруулж, үр дүнг иргэд, олон нийтэд нээлттэй байдлаар мэдээлж ажиллах.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд анхаарч, зорилтот үр дүндээ хүрээгүй ажлуудын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах.
3. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах. /Тайлангийн 2.3.1, 2.3.2 дахь хэсэг, нийт төсөвт өртөг 255.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ/

Аудитаар нийт 6,039.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн зөрчил арилгуулах 87.7 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 4,466.9 сая төгрөгийн 22 албан шаардлага, 1,484.4 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгч ажиллан хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 2 саналыг Үндэсний аудитын газарт уламжиллаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Анхаарах зүйл: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 4/10

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010164

Дорнод аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 27 дугаар сарын 25-ны өдрийн
11/0 дугаар тушаалын хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Аймгийн Засаг дарга	АРА-2024/26- ШТА-ГА ДОА-2024/26- 8-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,750,000
2	Баяндун сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	23,510,000
3	Баян-Уул сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	8,074,200
4	Дашбалбар сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	2,688,950
5	Матад сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	18,881,000
6	Халхгол сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	24,000,000
7	Цагаан-Овоо сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	1,308,000
8	Чулуунхороот сумын Засаг дарга		Төлбөр барагдуулах тухай	6,500,000
	Нийт дүн			87,712,150

Дорнод аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 27 дугаар сарын 25-ны өдрийн
11/0 дугаар тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая.төг/
1	Аймгийн Засаг дарга	АРА-2024/26- ШТА-ГА ДОА-2024/26- 8-ШТА-ГА	Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	-
2	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай	879.2
3	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай	4.9
4	Баяндун сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	193.0
5	Баяндун сумын Засаг дарга		Зөрчил арилгах тухай	15.0
6	Баян-Уул сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	335.4
7	Баянтүмэн сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	228.5
8	Баянтүмэн сумын Засаг дарга		Зөрчил арилгах тухай /НББ/	20.0
9	Булган сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	132.2
10	Гурванзагал сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	29.6
11	Дашбалбар сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	486.9
12	Дашбалбар сумын Засаг дарга		Зөрчил арилгах тухай	18.0
13	Сэргэлэн сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	55.3
14	Хөлөнбуйр сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	35.0
15	Хөлөнбуйр сумын Засаг дарга		Зөрчил арилгах тухай	8.2
16	Хэрлэн сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	1,090.3
17	Цагаан-Овоо сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	591.7
18	Чойбалсан сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	99.7
19	Чулуунхороот сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	234.0
20	Халхгол сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	-
21	Матад сумын Засаг дарга		Зөрчил арилгаж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах тухай	-
22	Матад сумын Засаг дарга		Зөрчил арилгах тухай	10.0
	Нийт дүн			4,466.9

---oOo---

Төсөл, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүндээ хүрээгүй шалтгаан, нөхцөлийн судалгаа

№	Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зорилтот үр дүндээ хүрээгүй шалтгаан	Хэрэгжилт дутуу	Он дамжих	Олт хэрэгжээгүй
1	Аймгийн ОНХС	Чойбалсан хотод авто зам шинээр тавих (Харлан сумын 4, 7, 9, 10, 11 дүгээр баг) төсөл, арга хэмжээний ажлын 1 дүгээр багц буюу "Нийтийн орон сууцны 19 дүгээр байрны баруун талаас орон сууцны 2 дугаар байр хүртэл хатуу хучилттай авто зам", төсөвт өртөг 206.3 сая төгрөг.	206.3	Харлан сумын 2-р байрны баруун талд байрлах хувийн аж ахуйн нэгжийн хашаат чөлөөлөх ажил хийгдээгүйгэй холбоотой ажил нь эзгээж, гүйцэтгэл 17 хувьтай байна. Газрын маргаан шүүхэд хянагдаж байна.	1		
2		Хэлхэйн талвирлогч баглуулах (Гурвансагал сум), төсөвт өртөг 45.0 сая төгрөг.	45.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
3		Нийтийн орон сууцны байрны гадна шугам сүлжээг шалгах (Харлан сумын 1, 6, 7, 8, 9, 10 дугаар багийн 1990 оноос өмнө баригдсан нийтийн орон сууцны байрууд) (багц 4, Орон сууцны ЦТТ-1-ийн оруулга), төсөвт өртөг 224.9 сая төгрөг	224.9	Тухайн онд хэрэгжилт дуусаагүй, хэрэгжилт 90 хувь, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	1		
4		Шинэ усан сан-9 төсөл (Харлан сум 3, 6, 8, 10 дугаар баг, Баянтүмэн, Сэргэлэн сум, багц-3, 5, 6), төсөвт өртөг 386.0 сая төгрөг	386.0	Тухайн онд хэрэгжилт дуусаагүй, хэрэгжилт 60 хувь, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	1		
5		Чойбалсан хотод авто зам шинээр тавих (Харлан сумын 4, 7, 9, 10, 11 дүгээр баг, багц 1), төсөвт өртөг 554.4 сая төгрөг	554.4	Тухайн онд хэрэгжилт дуусаагүй, хэрэгжилт 50 хувь, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	1		
6		Содномдаржаагийн гудамжаас Хяас, Ялалт хорооллын дундах босоо тэнгэрийн авто замыг үргэлжлүүлэх (Харлан сум, 10, 11 дугаар баг), төсөвт өртөг 677.1 сая төгрөг	677.1	Тухайн онд хэрэгжилт дуусаагүй, хэрэгжилт 50 хувь, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	1		
7		Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу бүрэлтэй авто зам (Харлан сум 7 дугаар баг), төсөвт өртөг 1,587.4 сая төгрөг	1,587.4	АИТХ-аар хасагдсан байна.			1
8		Төв болон туслах авто замын ус зайлуулах сүлжээг шалгах (Харлан сум), төсөвт өртөг 43.0 сая төгрөг	43.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
9		Жилснэй мод, хүнсний ногоо тариалалтыг дэмжих усан хангамжийг нэмэгдүүлэх, "Ногоон гудамж" төсөл хэрэгжүүлэх, төсөвт өртөг 250.0 сая төгрөг	250.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
10		Ялалт гурвнай 2 талд авто зам тавих ажлыг үргэлжлүүлэх, төсөвт өртөг 120.0 сая төгрөг	120.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
11		Айтсаамын ус зайлуулах байгууламж (Харлан сум), төсөвт өртөг 195.0 сая төгрөг	195.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
12		Чойбалсан хотын усан хангамжийн шугам хоолойд усны чанар сайжруулах тосгон тавихаарайх сурталуулах (Харлан сум), төсөвт өртөг 634.2 сая төгрөг	634.2	АИТХ-аар хасагдсан байна.			1
13		Хот хаягдал цөөрөгт булшлах (Харлан), төсөвт өртөг 300.0 сая төгрөг	300.0	Тухайн онд хэрэгжилт гараагүй, онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		1	
14	Харлан сумын ОНХС	1. Тогтоосмын талбай байгуулах, орчны тохижилт (2 дугаар баг), төсөвт өртөг 155.4 сая төгрөг.	155.4	Харлан сумын 2-р багт байрлах тогтоосмын талбайн газар нь хувийн аж ахуйн нэгжийн эзэмшлэйн газар тул шүүхээр хянагдаж байна. Талбайн тохижилт хийгдэж, сагсны талбайн ажил, тогтоосм суурилуулах ажил дутуу, гүйцэтгэл 80 хувьтай байна.	1		
15		2. Орон сууцны 22, 23 дугаар байрны гадна талбайн тохижилт, төсөвт өртөг 10.2 сая төгрөг.	10.2	Харлан сумын 22, 23 дугаар байрны дундах зам нь төв замын туслах зам тул хяалт хөйх боломжгүй байдал үүсэж хэрэгжээгүй байна. ИТХ-аар хасагдсан.			1
16		3. Тусгай зориулалтын хотны машин худалдах авах, төсөвт өртөг 145.0 сая төгрөг.	145.0	Аж ахуйн нэгжийн нийлүүлэх автомашин нь ажиллагаагаас заасан төмөрлөйн тодорхойлолтод нийцээгүй тул хүлээж аваагүй байна.			1
17		4. Хотын нийтийн зохих талбайн хамраагуулалт, төсөвт өртөг 200.0 сая төгрөг.	200.0	Төндөр шалгаруулалтад төндөр гарч, шүүхээр шийдвэргэгдэж, 2024 онд төндөрийг диван зарлахаар шийдвэрлэсэн байна.			1
18	Баянтүмэн сумын ОНХС	1. Гүн өрөөний цооног, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Төлөвлөсөн газар нь ус гараагүй тул 2024 онд хэрэгжүүлэхээр тохиролцсон байна.	1		
19		2. Нэгдсэн халаалтын зураг төсөв, төсөвт өртөг 60.0 сая төгрөг	60.0	Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан хэрэгжээгүй.		1	
20	Булган сумын ОНХС	1. 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөх буй зөрөнгийн оруулалтын барилга байгууламж их засварын ажлын зураг төсөв, төсөвт өртөг 5.0 сая төгрөг	5.0	Төсөв хүрээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.			1
21		2. Ангилалтын хашаа, төсөвт өртөг 48.0 сая төгрөг	48.0				1
22		3. Бэлчээрийн менежментийг сайжруулах, төсөвт өртөг 8.0 сая төгрөг	8.0				1
23		4. Эцэг мал эмнэлгээх, төсөвт өртөг 7.0 сая төгрөг	7.0	Малын тоо толгойн албан татавараас орж ирэх санхүүжилт бүрдээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.			1
24		5. Угвалтын ванн Хулсаншанд, Чулуут баг төсөвт өртөг 25.0 сая төгрөг	25.0				1
25		6. Баан-Уул багийн төвийн хашаажуулалт, төсөвт өртөг 10.0 сая төгрөг	10.0				1
26	Сэргэлэн сумын ОНХС	1. Халуун усны газрыг бохирын цооног холбох, тохижилт хийх, төсөвт өртөг 6.1 сая төгрөг	6.1	Халуун усны барилга дулаан алдагдал ихтэй ашиглах боломжгүй тул тус ажил хийгдээгүй байна.			1
27		2. Малчдад зориулсан сургалт, сурталчилгааг хийж, малын үүлдэр угсааг сайжруулах, төсөвт өртөг 12.0 сая төгрөг	12.0	Малын тоо толгойн албан татавараас орж ирэх орлого дутуу төвлөрсөн тул тус ажил хэрэгжээгүй байна.			1
28		3. Харлан мөргөцтэй тэмдэг, төсөвт өртөг 7.5 сая төгрөг	7.5	Хяналтын ажлаар хэргийн цагаан оготно хэвийн хэмжээнд байна гэсэн тус ажлыг хэрэгжүүлээгүй байна.			1
29		4. Гүн өрөөний худал, төсөвт өртөг 75.0 сая төгрөг	75.0	Гүйцэтгэл 60 хувьтай байна.	1		
30		5. Худ усны суурь барих, төсөвт өртөг 12.0 сая төгрөг	12.0	Малын тоо толгойн албан татавараас орж ирэх орлого дутуу төвлөрсөн тул тус ажил хэрэгжээгүй байна.			1
31	Матад сумын ОНХС	1. Сумын төвийн төвлөрсөн халаалт, төсөвт өртөг 495.1 сая төгрөг	495.1	Хэрэгжээгүй, гүйцэтгэл гараагүй байна.		1	
32		2. Бог мал угаах ванн Түмэншанд баг, төсөвт өртөг 25.0 сая төгрөг	25.0	"Нандин шүтээн" ХХК шалгарсан боловч гэрээ байгуулаагүй байна.			1
33	Гурвансагал сумын ОНХС	1. Ундны усны худалт цөөрөгүүлэх төвлөрөл, ухаалаг систем тавих, төсөвт өртөг 13.5 сая төгрөг	13.5	Худгийн ажил хийгдээгүйн улмаас тус төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.			1
34		2. Ундны усны худгийн байр шинээр барих, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Ажлын гүйцэтгэл хангалтгүй, гүйцэтгэл 40 хувь	1		
35		3. Гүн өрөөний цооног гаргах, төсөвт өртөг 40.0 сая төгрөг	40.0	Ажлын гүйцэтгэл 60 хувь	1		
36		4. Малчдад зориулсан сургалт, зөвлөгөөн" төсөвт өртөг 9.6 сая төгрөг	9.6	Зорилтот үр дүндээ хүрээгүй, малчид цуглаагүй шалтгаанаар зохион байгуулаагүй байна.			1
37	Чулуунхороот сумын ОНХС	1. Сумын төвийн гаралтүүлгийн шон худалдан авах байршуулах, төсөвт өртөг 87.1 сая төгрөг	87.1	Төндөр амжилтгүй болж хэрэгжээгүй			1
38		2. Орон нутгийн өмчтөг жүжүүд залуучуудын элсэхийн төвийн байр худалдан авах, төсөвт өртөг 50.0 сая төгрөг	50.0	Төндөр амжилтгүй болж хэрэгжээгүй			1
39		3. Соёлын төвийн дотор 00-д дэмжлэг, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Гүйцэтгэл дутуу, үр дүндээ хүрээгүй.	1		
40		1. Булаг хаших, төсөвт өртөг 5.9 сая төгрөг	5.9	Гэрээ байгуулагдаагүй тул хэрэгжээгүй байна.			1

41	Баян-Өлгий сумын ОНХС	2. Буриад омгийн хөнгө үүлдэрээр баталгаажуулах хөнгөн мөхдлэгаа хийх үйл ажиллагааны зардал, төсөвт өртөг 10.0 сая төгрөг	10.0	Гэрээ байгуулагдаагүй тул хэрэгжээгүй байна.			1
42	Баяндун сумын ОНХС	1. Нийтийн азамдлын талбайн төлөвлөлт, эрчилгээ, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Төндөрт оролцогч байгаагүй тул хэрэгжээгүй			1
43		2. Наранбулаг засмал ОНБААТҮГ, төсөвт өртөг 17.0 сая төгрөг	17.0	Үйл ажиллагаа явуулаагүй тул хэрэгжээгүй.			1
44		3. Мал улаарын ванн, төсөвт өртөг 40.0 сая төгрөг	40.0	Төндөрт оролцогч байгаагүй тул хэрэгжээгүй			1
45		4. "Нэг сум-нэг үүлдэр" малын үүлдэр сайжруулах, төсөвт өртөг 30.0 сая төгрөг	30.0	Төндөрт оролцогч байгаагүй тул хэрэгжээгүй			1
46	Баян-Уул сумын ОНХС	1. Эрээн бэлгэн төвийн ЖДҮ-ийн байрны нэмэлт засварын ажил, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Санхүүжилт дутуу олгогдсон тул хэрэгжээгүй байна.			1
47		2. Спорт тоглоомын талбайн нэмэлт төлөвлөлт, төсөвт өртөг 70.0 сая төгрөг	70.0	Санхүүжилт дутуу олгогдсон тул хэрэгжээгүй байна.			1
48		3. Зураг төсөв зохиох зардал, төсөвт өртөг 4.1 сая төгрөг	4.1	Санхүүжилт дутуу олгогдсон тул хэрэгжээгүй байна.			1
49		4. Эрээн давааны зам засвар, төсөвт өртөг 10.0 сая төгрөг	10.0	Санхүүжилт дутуу олгогдсон тул хэрэгжээгүй байна.			1
50	Цагаан-овоо сумын ОНХС	1. Мод үржүүлгийн талбай байгуулах, тохижуулах, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Оролцогч байгаагүй, хэрэгжээгүй байна.			1
51		2. Бэлчээрийн хортон мөргөлтэй тэмцэх, төсөвт өртөг 5.8 сая төгрөг	5.8	Эх үүсвэр оролцож, бүрдсэн тул хэрэгжээгүй байна.			1
52		3. Гүнцэнгэлт нуурын эко систем хамгаалах, тохижуулах, төсөвт өртөг 150.0 сая төгрөг	150.0	Гүйцэтгэл 30 хувьтай байна. Дутуу хэрэгжсэн.	1		
53		4. Баянгол адгийн гарам, төсөвт өртөг 15.0 сая төгрөг	15.0	Эх үүсвэр оролцож, бүрдсэн тул хэрэгжээгүй байна.			1
54		5. Малын үүлдэр угсаа сайжруулах (буриад омгийн хөнгө), төсөвт өртөг 5.0 сая төгрөг	5.0	Эх үүсвэр оролцож, бүрдсэн тул хэрэгжээгүй байна.			1
55		6. Улаарын ванн бүрдгэл Гүнцэнгэлт, төсөвт өртөг 20.0 сая төгрөг	20.0	Эх үүсвэр оролцож, бүрдсэн тул хэрэгжээгүй байна.			1
56	Халхынбуур сумын ОНХС	1. Мал улаалтын ванн – 2ххэрэг засвар, төсөвт өртөг 13.0 сая төгрөг	13.0	Төндөр оролцож зарлагдсан тул хэрэгжээгүй байна.			1
57		2. Хөг шалгах зуух зураг төсөв, 16.0 сая төгрөг	16.0	Гүйцэтгэл 50 хувьтай байна.	1		
58	Халхгол сумын ОНХС	1. Худал ташаагай бай, төсөвт өртөг 24.0 сая төгрөг	24.0	Хэрэгжээгүй.			1
59		2. АДАП худал, төсөвт өртөг 24.0 сая төгрөг	24.0	Хэрэгжээгүй.			1
НИЙТ			7,307.6		13	8	38

